



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/170/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usukhbayarj@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага	16
4.3 Зөвлөмж	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/66

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ЖАВЗАН ТАНАА

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D-Alban bichig 2022 A4 TOOT

0050?0375

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	891,123,943.75	3,907,485,155.34
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	3,721,232.37
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	3,721,232.37
3121	Төгрөг	00.00	3,721,232.37
31211	Төрийн сангийн харилцах	00.00	2,293,606.99
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	1,427,625.38
33	АВЛАГА	7,220,682.62	2,721,157,169.00
33200	Төлбөргүй үйлчилгээний авлага	00.00	2,719,859,181.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	2,904,716.62	00.00
335	Бусад авлага	4,315,966.00	1,297,988.00
3351	Байгууллагаас авах авлага	4,315,966.00	1,297,988.00
35	БАРАА МАТЕРИАЛ	883,903,261.13	1,182,606,753.97
351	Түүхий эд материал	459,121,826.48	862,745,494.15
35110	Тусгай зориулалттай материал	99,805,649.78	146,748,425.95
35130	Эм боох материал	359,316,176.70	715,997,068.20
354	Хангамжийн материал	424,781,434.65	319,861,259.82
35410	Бичиг хэргийн материал	6,219,742.00	1,473,850.00
35420	Аж ахуйн материал	6,738,554.20	14,047,088.20
35430	Сэлбэг хэрэгсэл	4,909,415.64	4,527,709.50
35440	Түлш, шатах тослох материал	247,500.00	14,633.00
35450	Барилгын засварын материал	6,503,084.00	1,616,000.00
35460	Хүнсний материал	2,747,800.00	884,800.00
35470	Бусад хангамжийн материал	397,415,338.81	297,297,179.12
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,932,111,656.18	17,044,781,811.35
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	13,932,111,656.18	17,044,781,811.35
392	Биет хөрөнгө	12,483,011,656.18	15,564,719,689.35
39201	Барилга, байгууламж, орон сууц	9,955,900,828.00	10,152,551,520.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-353,902,840.72	-523,305,916.60
39203	Авто-тээврийн хэрэгсэл	346,025,777.00	712,300,777.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-193,107,921.98	-235,215,435.28
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	6,734,608,888.20	10,165,784,348.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	-4,177,529,879.98	-4,947,865,552.21
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	480,868,749.98	591,372,499.98
39208	Хуримтлагдсан элэгдэл	-309,851,944.32	-350,902,551.96
393	Биет бус хөрөнгө	1,449,100,000.00	1,480,062,122.00
39301	Програм хангамж	4,744,900.00	36,007,022.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,469,900.00	-3,769,900.00
39303	Бусад биет бус хөрөнгө	1,447,825,000.00	1,447,825,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,823,235,599.93	20,952,266,966.69
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,823,235,599.93	20,952,266,966.69
51	Засгийн газрын хувь оролцоо	14,823,235,599.93	20,952,266,966.69
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	6,725,816,344.70	6,725,816,344.70
51101	Өмч: - төрийн	6,725,816,344.70	6,725,816,344.70
512	Хуримтлагдсан үр дүн	5,046,595,910.85	11,175,627,277.61
51210	Өмнөх үеийн үр дүн	5,046,595,910.85	5,046,595,910.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	6,129,031,366.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,050,823,344.38	3,050,823,344.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	14,823,235,599.93	20,952,266,966.69

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	12,297,822,243.23	21,064,595,587.43
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,013,922,547.23	5,596,990,848.05
120	Нийтлэг татварын бус орлого	3,013,922,547.23	5,596,990,848.05
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,013,922,547.23	5,596,990,848.05
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	183,553,844.00	214,930,320.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,830,368,703.23	5,382,060,528.05
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,283,899,696.00	15,467,604,739.38
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,440,643,200.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,440,643,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	327,203,888.00	1,101,022,557.38
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,279,532.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	119,719,356.00	621,445,723.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	202,205,000.00	479,576,834.38
1330	Төсвийн захирагчдаас	00.00	610,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	00.00	150,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	460,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,516,052,608.00	13,756,582,182.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	4,516,052,608.00	13,756,582,182.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,883,716,052.51	14,935,564,220.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,883,716,052.51	14,935,564,220.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,725,848,393.58	14,234,442,866.67
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,301,669,767.00	6,275,216,989.00
210101	Үндсэн цалин	5,301,460,917.00	3,226,970,233.00
210102	Нэмэгдэл	00.00	2,428,213,990.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	208,850.00	160,665,000.00
210104	Урамшуулал	00.00	459,367,766.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	678,771,297.00	827,910,428.81
210201	Тэтгэврийн даатгал	467,023,277.00	578,715,293.16
210202	Тэтгэмжийн даатгал	54,932,197.00	64,464,703.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	42,732,797.00	50,506,642.67
210204	Ажилгүйдлийн даатгал	10,368,893.00	12,202,163.59
210205	Эрүүл мэндийн даатгал	103,714,133.00	122,021,626.36
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	897,716,944.00	1,010,413,463.90
210301	Гэрэл, цахилгаан	91,611,981.00	112,183,552.90
210302	Түлц, халаалт	622,673,507.00	682,780,535.00
210303	Цэвэр, бохир ус	183,431,456.00	192,019,376.00
210304	Байрны түрээс	00.00	23,430,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	198,306,203.82	312,981,290.22
210401	Бичиг хэрэг	21,842,023.00	34,272,616.00
210402	Тээвэр, шатахуун	73,402,542.50	88,638,561.69
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	11,281,401.00	13,800,053.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	51,426,807.32	88,499,783.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,353,430.00	87,770,275.97
2105	Нормативт зардал	1,710,096,335.29	4,510,611,299.93
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,511,158,055.29	3,938,890,675.23
210502	Хоол, хүнс	198,938,280.00	404,790,169.00
210503	Нормын хувцас, зөөлөн элдэл	00.00	166,930,455.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,270,423.20	79,450,013.14
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	211,500.00	93,000.00
210604	Урсгал засвар	80,058,923.20	79,357,013.14
2107	Томилголт, зочны зардал	11,145,500.00	14,024,000.00
210702	Дотоод албан томилолт	11,145,500.00	14,024,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	124,913,554.00	164,208,683.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	98,455,650.00	146,455,741.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	712,800.00	1,425,598.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,250,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	189,178.00	253,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	940,000.00	00.00
210807	Газрын төлбөр	5,791,300.00	5,791,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	15,594,626.00	7,783,044.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	722,958,369.27	1,039,626,698.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	16,429,829.62
210903	Үндсэн хөрөнгийн эзгдэл, хорогдол	722,958,369.27	1,023,196,869.05

Баянхонгор аймаг дахь Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	157,867,658.93	701,121,354.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	155,591,356.00	701,121,354.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	119,719,356.00	62,133,192.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	35,872,000.00	638,988,162.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,276,302.93	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,276,302.93	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,414,106,190.72	6,129,031,366.76
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	959,707.53	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	959,707.53	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-959,707.53	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,413,146,483.19	6,129,031,366.76

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	9,467,453,540.00	12,964,612,765.38
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	183,553,844.00	214,930,320.00
120	Нийтлэг татварын бус орлого	183,553,844.00	214,930,320.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	183,553,844.00	214,930,320.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	183,553,844.00	214,930,320.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,283,899,696.00	12,749,682,445.38
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,440,643,200.00	00.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,440,643,200.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	327,203,888.00	1,102,959,444.38
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,279,532.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	119,719,356.00	621,445,723.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	202,205,000.00	481,513,721.38
1330	Төсвийн захирагчдаас	00.00	610,000,000.00
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	00.00	150,000,000.00
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	00.00	460,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,516,052,608.00	11,036,723,001.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	4,516,052,608.00	11,036,723,001.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	9,352,189,540.00	12,850,988,033.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,352,189,540.00	12,850,988,033.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,223,958,681.07	12,758,472,033.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,267,716,464.00	6,253,371,497.00
210101	Үндсэн цалин	2,722,907,651.00	2,892,680,621.00
210102	Нэмэгдэл	1,842,748,329.89	2,719,012,002.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	218,594,715.18	211,106,822.00
210104	Урамшуулал	483,465,767.93	430,572,052.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	712,724,600.00	814,640,073.81
210201	Тэтгэврийн даатгал	501,547,000.00	587,248,006.31
210202	Тэтгэмжийн даатгал	52,794,400.00	57,961,876.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	42,235,500.00	45,821,740.56
210204	Ажилгүйдлийн даатгал	10,558,900.00	11,237,159.42
210205	Эрүүл мэндийн даатгал	105,588,800.00	112,371,291.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	897,716,944.00	1,010,413,463.90
210301	Гэрэл, цахилгаан	91,611,981.00	112,183,552.90
210302	Түлш, халаалт	622,673,507.00	682,780,535.00
210303	Цэвэр, бохир ус	183,431,456.00	192,019,376.00
210304	Байрны түрээс	00.00	23,430,000.00

Баянхонгор аймаг дахь Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2104	Хангамж, бараа материалын зардал	178,888,632.00	201,459,532.56
210401	Бичиг хэрэг	12,516,026.00	8,339,528.00
210402	Тээвэр, шатахуун	71,500,000.00	84,753,000.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	11,281,401.00	14,266,833.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,315,405.00	52,917,621.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	43,275,800.00	41,182,550.00
2105	Нормативт зардал	1,807,173,549.07	3,099,048,236.74
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,572,604,119.07	2,643,460,567.74
210502	Хоол, хүнс	201,074,680.00	402,032,369.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	33,494,750.00	53,555,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	112,498,340.00	88,832,163.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,060,000.00	5,025,000.00
210602	Тавилга	00.00	2,320,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	56,828,000.00	7,871,000.00
210604	Урсгал засвар	38,610,340.00	73,615,363.00
2107	Томилолт, зочны зардал	10,681,500.00	13,876,000.00
210702	Дотоод албан томилолт	10,681,500.00	13,876,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	236,558,652.00	1,258,893,098.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	199,699,582.00	1,223,435,560.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,980,000.00	2,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	712,800.00	1,425,598.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,250,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	189,178.00	253,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,535,792.00	00.00
210807	Газрын төлбөр	5,791,300.00	5,791,300.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	24,400,000.00	25,487,640.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	17,937,968.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	17,937,968.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	128,230,858.93	92,516,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	125,954,556.00	92,516,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	119,719,356.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,235,200.00	92,516,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,276,302.93	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,276,302.93	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	115,264,000.00	113,624,732.37
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	115,264,000.00	109,903,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	115,264,000.00	109,903,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	115,264,000.00	109,903,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	115,264,000.00	109,903,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-115,264,000.00	-109,903,500.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	3,721,232.37
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	3,721,232.37

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,277,991,344.70	2,935,236,347.00	-119,985,806.28	8,093,241,885.42
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,277,991,344.70	2,935,236,347.00	-119,985,806.28	8,093,241,885.42
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-110,448,584.16	-110,448,584.16
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,725,816,344.70	3,050,823,344.38	5,046,595,910.85	14,823,235,599.93
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,725,816,344.70	3,050,823,344.38	5,046,595,910.85	14,823,235,599.93
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,725,816,344.70	3,050,823,344.38	5,046,595,910.85	14,823,235,599.93
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	6,129,031,366.76	6,129,031,366.76
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,725,816,344.70	3,050,823,344.38	11,175,627,277.61	20,952,266,966.69

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		/ төгрөгөөр /	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	11,889,766,200.00	11,859,359,714.01	30,406,485.99	99.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,889,766,200.00	11,859,359,714.01	30,406,485.99	99.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,797,250,200.00	11,766,843,714.01	30,406,485.99	99.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,253,371,500.00	6,253,371,497.00	03.00	100.00
210101	Үндсэн цалин	2,933,725,200.00	2,892,680,621.00	41,044,579.00	98.60
210102	Нэмэгдэл	2,656,441,500.00	2,719,012,002.00	-62,570,502.00	102.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	223,146,000.00	211,106,822.00	12,039,178.00	94.60
210104	Урамшуулал	440,058,800.00	430,572,052.00	9,486,748.00	97.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	844,205,200.00	814,640,073.81	29,565,126.19	96.50
210201	Тэтгэврийн даатгал	594,070,600.00	587,248,006.31	6,822,593.69	98.85
210202	Тэтгэмжийн даатгал	62,533,500.00	57,961,876.04	4,571,623.96	92.69
210203	ҮОМШӨ-ний даатгал	50,027,000.00	45,821,740.56	4,205,259.44	91.59
210204	Ажилгүйдлийн даатгал	12,506,700.00	11,237,159.42	1,269,540.58	89.85
210205	Эрүүл мэндийн даатгал	125,067,400.00	112,371,291.48	12,696,108.52	89.85
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,012,628,700.00	1,010,413,463.90	2,215,236.10	99.78
210301	Гэрэл, цахилгаан	112,200,000.00	112,183,552.90	16,447.10	99.99
210302	Түлш, халаалт	682,780,600.00	682,780,535.00	65.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	194,218,100.00	192,019,376.00	2,198,724.00	98.87
210304	Байрны түрээс	23,430,000.00	23,430,000.00	00.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	202,053,600.00	202,052,519.56	1,080.44	100.00
210401	Бичиг хэрэг	8,339,500.00	8,339,528.00	-28.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	84,753,000.00	84,753,000.00	00.00	100.00
210403	Шуудан, холбоо, ингернэгийн төлбөр	14,095,200.00	14,094,200.56	999.44	99.99
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	47,993,400.00	47,993,341.00	59.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	46,872,500.00	46,872,450.00	50.00	100.00
2105	Нормативт зардал	3,106,162,000.00	3,106,161,949.74	50.26	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,643,633,200.00	2,643,633,200.74	-00.74	100.00
210502	Хоол, хүнс	407,677,500.00	407,677,449.00	51.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	54,851,300.00	54,851,300.00	00.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	185,023,200.00	179,687,963.00	5,335,237.00	97.12
210601	Багаж, техник, хэрэгсэл	120,633,000.00	85,633,000.00	35,000,000.00	70.99
210602	Тавилга	12,249,500.00	12,249,500.00	00.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	21,204,300.00	7,871,000.00	13,333,300.00	37.12
210604	Урсгал засвар	30,936,400.00	73,934,463.00	-42,998,063.00	238.99
2107	Томилолт, зочны зардал	23,681,500.00	13,876,000.00	9,805,500.00	58.59
210702	Дотоод албан томилолт	23,681,500.00	13,876,000.00	9,805,500.00	58.59
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	170,124,500.00	168,702,279.00	1,422,221.00	99.16
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	133,244,800.00	133,244,741.00	59.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,500,000.00	2,500,000.00	00.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,425,600.00	1,425,598.00	02.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,250,000.00	00.00	1,250,000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	623,700.00	253,000.00	370,700.00	40.56
210807	Газрын төлбөр	5,791,200.00	5,791,300.00	-100.00	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	25,289,200.00	25,487,640.00	-198,440.00	100.78
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	17937968.00	-17937968.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	17,937,968.00	-17,937,968.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	92,516,000.00	92,516,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	92,516,000.00	92,516,000.00	00.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	92,516,000.00	92,516,000.00	00.00	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	11,889,766,200.00	11,861,653,321.00	28,112,879.00	99.76
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,691,753,900.00	00.00	4,691,753,900.00	00.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,691,753,900.00	00.00	4,691,753,900.00	00.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,021,780,600.00	11,646,723,001.00	-4,624,942,401.00	165.87
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	7,021,780,600.00	11,646,723,001.00	-4,624,942,401.00	165.87
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	176,231,700.00	214,930,320.00	-38,698,620.00	121.96
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	176,231,700.00	214,930,320.00	-38,698,620.00	121.96
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	2,293,606.99	-2,293,606.99	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	322.00	331.00	-09.00	102.80
620001	Удирдах ажилтан	01.00	02.00	-01.00	200.00
620002	Гүйцэтгэх ажилтан	150.00	229.00	-79.00	152.67
620003	Үйлчлэх ажилтан	171.00	100.00	71.00	58.48
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	322.00	331.00	-09.00	102.80
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	282.00	288.00	-06.00	102.13
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	40.00	43.00	-03.00	107.50

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Тайлант он
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	327203888.00	1,101,531,819.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	327203888.00	1,101,531,819.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	205547645.00	1,101,531,819.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	205547645.00	1,101,531,819.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	205547645.00	1,101,531,819.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	119719356.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	119719356.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	119719356.00	00.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1936887.00	00.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	1936887.00	00.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	327203888.00	1102959444.38
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	327203888.00	1102959444.38
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5279532.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	119719356.00	621,445,723.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	202205000.00	481,513,721.38
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1427625.38

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 63 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын төсвийн зарцуулалтад 1 дүгээр гарын үсгийг 2021.01.01-2021.04.07 мөн 2021.12.06-2021.12.31-ний хооронд Ч.Жавзан, 2021.04.07-2021.12.06-ны хооронд А.Ганболд, 2 дугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Д.Сайнбаяр нар зурсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний жишигт нийцсэн үйл ажиллагаатай, орчин үеийн дэвшилтэд технологийг тасралтгүй нэвтрүүлсэн, салбартаа найдвартай, нэр хүнд бүхий, тэргүүлэгч эмнэлэг байх
- Хүний нөөцийн ур чадвар, ёс зүй, манлайлал бүхий хамт олонд тулгуурлан, үйлчилгээний таатай орчинд хоёр дахь шатлалын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, ээлтэй, цогц үзүүлэх замаар хонгор нутгийн хөгжил, ард иргэдийн амьдралын чанарыг сайжруулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Эрүүл мэндийн яамны дотоод аудитын хэлтэс нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 9,883,716.1 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 49,418.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 43,046.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,016,361.2 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	891,123.9	3,907,485.2	3,016,361.2
Мөнгөн хөрөнгө	-	3,721.2	3,721.2
Авлага	7,220.7	2,721,157.2	2,713,936.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	883,903.3	1,182,606.8	298,703.5
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	13,932,111.7	17,044,781.8	3,112,670.2
Үндсэн хөрөнгө	18,969,974.1	23,105,841.2	4,135,867.0
Хуримтлагдсан элэгдэл	(5,037,862.5)	(6,061,059.4)	(1,023,196.9)
Нийт хөрөнгө	14,823,235.6	20,952,267.0	6,129,031.4
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	14,823,235.6	20,952,267.0	6,129,031.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	14,823,235.6	20,952,267.0	6,129,031.4

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь тайлант онд үндсэн дансны үлдэгдэл 2,293.6 мянга, нэмэлт дансны үлдэгдэл 1,427.6 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг тайлагнасан байна.

Авлагын дансны үлдэгдэл 2,721,157.2 мянган төгрөг болж 2,713,936.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үндсэн тусламж үйлчилгээний 828,203.6 мянга, Ковид-19 цар тахлын хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний 1,883,120.0 мянга, PCR шинжилгээний сорьц цуглуулах ажлын 4,106.0 мянга, төлбөрийг нь төр хариуцах эмийн 4,429.5 мянган төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,182,606.8 мянган төгрөг болж 298,703.5 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал данс 46,942.8 мянга, 356,6680.9 мянган төгрөгөөр нэмэгдэж бусад хангамжийн материал данснаас байгууллагын даргын 2021 оны А/174 дүгээр тушаалын дагуу 100,118.2 мянган төгрөгийн бараа материал акталж данснаас хассан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 23,105,841.2 мянган төгрөг болж 4,135,867.0 мянган төгрөгөөр өссөн нь 109,903.5 мянган төгрөгийн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, 4,025,963.5 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үнэ төлбөргүй хүлээн авсан 4,025,963.5 мянган төгрөгийн хөрөнгө нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар мэс заслын тасгийн дээвэр, гадна пасадны засварыг 69,420.4 мянга, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төрөх эмэгтэйчүүдийн амрах байрны засвар, мэдрэлийн тасгийн дээврийн засварыг 108,730.2 мянган төгрөгөөр санхүүжүүлснийг хөрөнгийн сайжруулалтаар бүртгэсэн.

Мөн Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 1,218,189.6 мянга, Эх хүүхдийн эрүүл мэндийн төвөөс 18,000.0 мянга, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 1,380,000.0 мянга, аймгийн ЗДТГ-аас 38,306.0 мянга, аймгийн онцгой комиссоос 159,698.9 мянга, бусад аж ахуйн нэгж байгууллагуудаас 1,033,618.3 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 20,952,267.0 мянган төгрөг болж 6,129,031.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 6,129,031.4 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 9,818,282.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 9,818,282.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 448,747.5 мянган төгрөгөөр бууруулж 9,369,535.4 мянган төгрөгөөр анх батлагдсан ба Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/752 дугаар тушаалаар нэг удаа тодотгол хийж 11,889,766.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолын дагуу гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 11,036,723.0 мянга,

Эрүүл мэндийн яамны нэмэлт санхүүжилтийн данснаас 150,000.0 мянга, Засгийн газрын нөөц сангаас 460,000.0 мянга нийт 11,646,723.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, үндсэн үйл ажиллагааны орлогоор 214,930.3 мянга нийт 11,861,653.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 11,859,359.7 мянган төгрөгийг зарцуулж 2,293.6 мянган төгрөгийг дансны үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 11,859,359.7 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 29,565.1 мянган төгрөгөөр зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 621,445.7 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 481,513.7 мянга нийт 1,102,959.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 1,101,531.8 мянган төгрөгийг зарцуулж 1,427.6 мянган төгрөгийг дансны үлдэгдлээр тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээлэл, тайлант оны түргэвчилсэн төстийн орлого, зарцуулалт, ковидын санхүүжилт, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгчийн гэрээний үнэ зэргийг хамруулаагүй болно.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн хуулийн дагуу Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолын дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилж гүйцэтгэлээр санхүүжиж байна.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилго, 9 зорилтын хүрээнд 72 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах гүйцэтгэлийн санхүүжилт, өглөг, авлагыг Баянхонгор аймаг дахь Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй зарим зардлыг тооцоо нийлэн баталгаажуулаагүй, тооцоо нийлэн баталгаажуулсан ч Нэгдсэн эмнэлгийн статистикч эмчийн тооцоо, www.health.gov.mn цахим системийн бүртгэлээс зөрүүтэй байсан нь аудит хийхэд цаг хугацаа шаардсан болно. Тухайлбал: ПГУ шинжилгээний сорьц цуглуулах ажлыг санхүүжилтийг 2022.02.13-д, төр хариуцах эмийн зардлын санхүүжилтийг 2022.02.21-д тооцоо нийлж баталгаажуулсан. Тус

санхүүжилтүүдтэй холбоотой 8,535.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тооцоо нийлсэн байна.

Үндсэн тусламж үйлчилгээний орлого болон нэмэлтээр хэрэгжүүлсэн Ковид-19 цар тахалтай холбоотой сорьц, шинжилгээ, хэвтэн эмчилгээний санхүүжилт, авлагыг Эрүүл мэндийн даатгалын тасагтай тооцоо нийлсэн актын дүнгээр баталгаажуулсан болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд оруулбал зохих 23,512,474.0 мянган төгрөгийн 165 мэдээллээс 163 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 7, 8 дугаар саруудад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой 2,369,800.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаа төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулсан байна. Тухайлбал:

Нээлттэй тендер: Эм эмнэлгийн хэрэгсэл худалдан авах 53 багцыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж 21 компанитай, түлш, шатах тослох материал худалдан авах ажиллагааг 1 багцад багцыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж 1 компанитай, хоол хүнсний материал бэлтгэн нийлүүлэх худалдан авах ажиллагааг 6 багцад нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж 4 компанитай тус тус гэрээ байгуулсан байна.

Харьцуулалтын аргаар: Тасаг нэгжид хийгдэх урсгал засвар, анхан шатны маягт, журнал бэлтгэн нийлүүлэх, багаж хэрэгсэл бэлтгэн нийлүүлэх, бага үнэтэй түргэн элэгдэх материалын тендер, цэвэрлэгээ аж ахуйн материалын тендер, нормын хувцас зөөлөн эдлэлийн тендерийг тус тус хуулийн хугацаанд зарлан тендерт оролцогчдод өгөх зөвлөмжийн ерөнхий шаардлага хангасан аж ахуй нэгжүүдтэй гэрээ байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 15,521.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 3,118.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 10,664.1 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1,738.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант оны Ковидын түргэвчилсэн тестийн орлого, зарцуулалт, ковидын санхүүжилт, эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахдаа нийлүүлэгч гэрээний үнийг мөрдсөн эсэх зэргийг санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаанаас хамаарч бүрэн хамруулах боломжгүй байсан тул дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 112,209.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 82,875.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 546.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 20,251.6 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгч, 8,535.5 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

1. Тайлант хугацаанд ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар олгосон 49,450.0 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмжийг хүлээн авсан ч хөрөнгийн бүртгэлд бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Ангилал”, “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн дансанд 49,450.0 мянган төгрөгийн хөрөнгүүдийг бүртгэж залруулав.

2. Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар 2021 оны 04 дүгээр сард аймгийн Эрүүл мэндийн газар болон аймгийн техник хяналтын барьцаа данснаас 33,425.7 мянган төгрөгийн санхүүжилтийг Ковид-19 цар тахлын үед ажилласан ажилчдын илүү цагийн цалинд олгохоор авч түргэвчилсэн тестийн орлогоос буцаан төлсөн ч мөнгөн гүйлгээний тайланд цэвэрлэж тохируулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар”-ын 6.6 дахь “Үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний нийлбэрээр нийт цэвэр мөнгөн гүйлгээг тодорхойлно” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Ангилал” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мөнгөн гүйлгээний тайланд залруулав.

4.2 Төлбөрийн акт

1. Цалингийн зардлаас 8,11,12 дугаар саруудад 7 албан хаагчаас 157.7 мянган төгрөгийн цалингийн зөрүүг суутган аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох ажилтнуудаар 157.7 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тус байгууллагын төсвийн захирагч нь 10, 11 дүгээр саруудад өөртөө шийдвэр гаргаж 389.3 мянган төгрөгийн ёс зүй харилцаа хандлагын урамшуулал авсан байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар 389.3 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

1. Ажиллагсдын цалинг Нийгмийн даатгалын хэлтэст 596.1 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх "ажил олгогч нь хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ажилчдын 2021 оны 596.1 мянган төгрөгийн цалинг залруулж мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага өгөв.

2. Тайлант онд Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 58,966.5 мянган төгрөгийн үнэ 30ш компьютер ирснээс АЗДТГ нь 19,655.5 мянган төгрөгийн 10ш компьютерыг авч ашиглаж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тус байгууллагад Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн 19,655.5 мянган төгрөгийн 10 компьютерыг хүлээлгэн өгөх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-т өгөв.

4.3 Зөвлөмж

1. Тайлант хугацаанд оруулбал зохих 165 мэдээллээс 163 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 7, 8 дугаар саруудад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээтэй холбоотой 2,369.8 сая төгрөгийн 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.5 дахь “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь мэдээлж цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2. Тус байгууллага нь гүйцэтгэлийн санхүүжилт, өглөг, авлагыг Баянхонгор аймаг дахь ЭМД-ын хэлтэстэй тооцоо нийлэн баталгаажуулаагүйгээс аудит хийхэд цаг хугацаа шаардсан болно. Тухайлбал ПГУ шинжилгээний сорьц цуглуулах ажлыг санхүүжилтийг 2022.02.13-д, төр хариуцах эмийн зардлын санхүүжилтийг 2022.02.21-д тооцоо нийлж баталгаажуулсан. Тус санхүүжилтүүдтэй холбоотой 8,535.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй тооцоо нийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй тусламж, үйлчилгээний гүйцэтгэл, санхүүжилт, өглөг, авлагын тооцоог сар бүр нийлж баталгаажуулж байх зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг	8	112,209.7	2	82875.7	2	546.9	2	20251.6	2	8535.5

_____оОо_____